

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/259/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэл
захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИХ	Ардын Их Хурал
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024-02-05 № 01/100.
танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ч.БУМДАРЬ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 146,920.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 74,89 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,279,197.54	214,144,879.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,451,982.27	146,188,020.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	25,451,982.27	146,188,020.13
3121	Төгрөг	25,451,982.27	146,188,020.13
31211	Төрийн сангийн харилцах	25,451,982.27	146,188,020.13
35	БАРАА МАТЕРИАЛ	60,827,215.27	67,956,858.87
351	Түүхий эд материал	278,426.00	278,426.00
35110	Тусгай зориулалттай материал	278,426.00	278,426.00
354	Хангамжийн материал	54,378,789.27	62,388,432.87
35410	Бичиг хэргийн материал	879,500.00	637,500.00
35420	Аж ахуйн материал	4,506,100.00	5,027,200.00
35460	Хүнсний материал	685,700.00	1,371,923.60
35470	Бусад хангамжийн материал	48,307,489.27	55,351,809.27
35600	Мал амьтад	6,170,000.00	5,290,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,447,837,606.50	2,584,985,722.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,447,837,606.50	2,584,985,722.59
392	Биет хөрөнгө	2,378,291,606.50	2,515,439,722.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,410,018,471.00	2,423,251,471.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(180,401,172.36)	(240,782,175.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,666,666.52)	(4,666,666.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	140,121,750.60	219,179,516.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,066,767.78)	(74,113,312.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,585,392.86	123,580,720.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,063,542.36)	(34,647,677.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,964,002.00	86,505,707.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,628,000.48)	(6,296,000.96)
39217	Ном	13,428,139.54	13,428,139.54
393	Биет бус хөрөнгө	69,546,000.00	69,546,000.00
39301	Програм хангамж	784,500.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(784,500.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	69,546,000.00	69,546,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,534,116,804.04	2,799,130,601.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,242,884.00	35,421,925.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,242,884.00	35,421,925.75
413	Өглөг	23,242,884.00	35,421,925.75
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	23,242,884.00	35,421,925.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,510,873,920.04	2,763,708,675.84

51	Засгийн газрын хувь оролцоо	2,510,873,920.04	2,763,708,675.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	602,708,368.54	602,708,368.54
51101	Өмч: - төрийн	602,708,368.54	602,708,368.54
512	Хуримтлагдсан үр дүн	1,169,815,366.82	1,422,650,122.62
51210	Өмнөх үеийн үр дүн	1,194,929,176.12	,169,815,366.82
51220	Тайлант үеийн үр дүн	(25,113,809.30)	252,834,755.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	738,350,184.68	738,350,184.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,534,116,804.04	2,799,130,601.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,255,288,753.15	1,688,296,653.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,725,400.00	231,250,905.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,725,400.00	218,017,905.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,725,400.00	218,017,905.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,725,400.00	218,017,905.00
122	Тусламжийн орлого	-	13,233,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	13,233,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,243,563,353.15	1,457,045,748.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	942,039,253.15	1,243,737,948.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	950,825,200.00	1,243,737,948.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	(8,785,946.85)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,716,600.00	1,532,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,716,600.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,532,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	244,807,500.00	211,775,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	244,807,500.00	211,775,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,281,958,585.73	1,430,818,667.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,281,958,585.73	1,430,818,667.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,174,281,075.05	1,405,866,279.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	699,073,730.48	827,120,328.41
210101	Үндсэн цалин	472,819,769.59	574,146,341.50
210102	Нэмэгдэл	173,950,756.22	215,316,789.31
210104	Урамшуулал	37,089,496.73	37,657,197.60
210105	Гэрээт ажлын хөлс	15,213,707.94	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,361,684.40	104,270,574.73
210201	Тэтгэврийн даатгал	60,526,684.98	70,921,688.99

210202	Тэтгэмжийн даатгал	7,195,040.18	8,790,015.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,595,828.95	6,655,171.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,367,647.96	1,625,192.50
210205	Эрүүл мэндийн даатгал	13,676,482.33	16,278,506.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,997,256.32	222,222,532.86
210301	Гэрэл, цахилгаан	11,623,672.32	13,760,691.11
210302	Түлш, халаалт	187,199,584.00	203,461,841.75
210303	Цэвэр, бохир ус	5,174,000.00	5,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,592,852.00	11,394,030.00
210401	Бичиг хэрэг	6,686,202.00	4,512,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,297,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,906,650.00	4,395,800.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,188,280.00
2105	Нормативт зардал	62,914,161.00	93,175,922.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,000.00	-
210502	Хоол, хүнс	62,811,161.00	93,175,922.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,558,800.00	7,179,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,532,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,558,800.00	5,647,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,782,590.85	139,503,091.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,541,976.00	21,410,948.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,193,000.00	7,530,975.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,047,614.85	110,561,168.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,677,510.68	24,952,388.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,487,483.00	24,952,388.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,535,955.00	24,952,388.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(26,669,832.58)	257,477,985.14
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	20,000,000.00	-
14	Төсөвт байгууллагын орлого	20,000,000.00	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,910,920.45
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,910,920.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	20,000,000.00	(3,910,920.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,669,832.58)	253,567,064.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,243,563,353.15	1,457,045,748.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,243,563,353.15	1,457,045,748.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	942,039,253.15	1,243,737,948.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	950,825,200.00	1,243,737,948.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	(8,785,946.85)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,716,600.00	1,532,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,716,600.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,532,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	244,807,500.00	211,775,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	244,807,500.00	211,775,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,183,796,902.88	1,298,368,101.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,183,796,902.88	1,298,368,101.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,062,585,557.20	1,238,940,901.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	698,685,956.67	828,666,444.50
210101	Үндсэн цалин	470,670,765.75	569,891,719.14
210102	Нэмэгдэл	175,711,988.43	218,860,931.76
210104	Урамшуулал	37,089,494.55	39,913,793.60
210105	Гэрээт ажлын хөлс	15,213,707.94	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,749,458.21	102,724,458.64
210201	Тэтгэврийн даатгал	60,647,982.18	69,949,980.76
210202	Тэтгэмжийн даатгал	7,078,093.10	8,470,892.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,642,253.87	6,560,198.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,383,401.75	1,610,362.49
210205	Эрүүл мэндийн даатгал	13,997,727.31	16,133,024.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	180,580,372.32	210,043,491.11
210301	Гэрэл, цахилгаан	11,623,672.32	13,760,691.11
210302	Түлш, халаалт	163,956,700.00	191,282,800.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	5,000,000.00
2105	Нормативт зардал	49,661,270.00	59,387,334.00
210502	Хоол, хүнс	49,661,270.00	59,387,334.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,558,800.00	7,179,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,532,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,558,800.00	5,647,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,349,700.00	29,939,373.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,529,500.00	19,362,348.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,820,200.00	10,577,025.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,211,345.68	59,427,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,021,318.00	59,427,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,911,050.00	59,427,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,445,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,420,568.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,244,200.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	190,027.68	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	190,027.68	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	59,766,450.27	158,677,646.75
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	59,165,000.00	37,209,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,165,000.00	37,209,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,165,000.00	37,209,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,165,000.00	37,209,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(59,165,000.00)	(37,209,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	601,450.27	121,468,346.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,451,982.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,601,450.27	146,920,329.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,194,929,176.12	2,535,987,729.34
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,194,929,176.12	2,535,987,729.34
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-25,113,809.30	-25,113,809.30

10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,169,815,366.82	2,510,873,920.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,169,815,366.82	2,510,873,920.04
19	Тайлант үеийн үр дүн	0	0	252,834,755.80	252,834,755.80
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,422,650,122.62	2,763,708,675.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,456,313,438.61	1,335,577,401.25	120,736,037.36	92%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,456,313,438.61	1,335,577,401.25	120,736,037.36	92%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,244,537,638.61	1,276,150,201.25	(31,612,562.64)	103%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	793,872,438.61	828,666,444.50	(34,794,005.89)	104%
210101	Үндсэн цалин	558,740,538.61	569,891,719.14	(11,151,180.53)	102%
210102	Нэмэгдэл	198,974,300.00	218,860,931.76	(19,886,631.76)	110%
210104	Урамшуулал	36,157,600.00	39,913,793.60	(3,756,193.60)	110%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,660,900.00	102,724,458.64	(10,063,558.64)	111%
210201	Тэтгэврийн даатгал	63,075,400.00	69,949,980.76	(6,874,580.76)	111%
210202	Тэтгэмжийн даатгал	7,420,600.00	8,470,892.41	(1,050,292.41)	114%
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,936,500.00	6,560,198.44	(623,698.44)	111%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,484,100.00	1,610,362.49	(126,262.49)	109%
210205	Эрүүл мэндийн даатгал	14,744,300.00	16,133,024.54	(1,388,724.54)	109%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,775,800.00	210,043,491.11	732,308.89	100%
210301	Гэрэл, цахилгаан	14,493,000.00	13,760,691.11	732,308.89	95%
210302	Түлш, халаалт	191,282,800.00	191,282,800.00	-	100%
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	5,000,000.00	-	100%
2105	Нормативт зардал	64,746,600.00	59,387,334.00	5,359,266.00	92%
210502	Хоол, хүнс	64,746,600.00	59,387,334.00	5,359,266.00	92%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100%
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,063,300.00	7,179,800.00	(116,500.00)	102%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,532,000.00	(1,532,000.00)	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,063,300.00	5,647,800.00	1,415,500.00	80%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,418,600.00	67,148,673.00	7,269,927.00	90%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,571,648.00	56,571,648.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,577,025.00	10,577,025.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,431,300.00	59,427,200.00	4,100.00	100%

2132	Бусад урсгал шилжүүлэг	59,431,300.00	59,427,200.00	4,100.00	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,431,300.00	59,427,200.00	4,100.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,457,045,800.00	1,335,577,391.11	121,468,408.89	92%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,245,270,000.00	1,124,533,900.00	120,736,100.00	90%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	211,775,800.00	211,043,491.11	732,308.89	100%
122005	Орон нутгийн төсвөөс	211,775,800.00	211,043,491.11	732,308.89	100%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,451,982.27	(25,451,982.27)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	146,188,020.13	(146,188,020.13)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль нь Монгол Улсын боловсролын ерөнхий хуулийн дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2023-2024 оны хичээлийн жилд хамтын оролцоонд суурилсан сургуулийн менежментийг сайжруулах жил болгон үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Үүний хүрээнд сургуулийн үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт хийж сургалтын чанарыг сайжруулахыг эрхэм зорилго болгож ажиллаж байна.

Алсын хараа

Асуудлыг шинжлэх ухаанч арга барилаар шийдвэрлэдэг, Өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг иргэнийг бэлтгэх

Зорилт

- ✓ Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулийг сургалтын байгууллага бүрийн багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор "Хуулиа хэрэгжүүлэе" аяныг зохион байгуулах
- ✓ Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар дэмжих, сургуульд элсэн суралцсан 6 настанд дасан зохицох бэлтгэл хангах.
- ✓ Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх суурь зарчимд тулгуурлан байршлаас хамаарсан үйлчилгээний чанарын ялгааг бууруулж хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэг, сургуульд хамрагдах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэх
- ✓ Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах
- ✓ Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологи (сургалтын платформ)-д суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага, суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар багшийн арга зүйд ахиц гаргах
- ✓ Суралцагчдын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг анги, бүлгээс үл хамааран багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг хагас жил бүр тооцох
- ✓ Суралцахуй болон судлагдахуунд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг дэмжиж, ажлын гүйцэтгэл, үр дүнд шинжилгээ хийх, багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглах замаар багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх ур чадварт гарсан ахиц, өөрчлөлт, үр дүнг тооцох
- ✓ Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, тэгш боломж олгох орчныг сургалтын байгууллага бүр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн дэмжлэгтэйгээр бүрдүүлж, дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулах замаар тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх
- ✓ Мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагч бүрийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран MEDLE.mn сургалтын үндэсний нэгдсэн платформыг ашиглан суралцах тэгш боломж бүрдүүлэх

- ✓ Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагын дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цээл сумын ерөнхий боловсролын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Сургууль нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн А/02

дугаар тушаалаар батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна.

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 265,013.8 мянган төгрөгөөр буюу 10,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	25,451.9	146,188.0	120,736.0
Бараа материал	60,827.2	67,956.9	7,129.6
Үндсэн хөрөнгө	2,447,837.6	2,584,985.7	137,148.1
Нийт хөрөнгө	2,534,116.8	2,799,130.6	265,013.8
Өр төлбөр	23,242.9	35,421.9	12,179.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	602,708.4	602,708.4	
Хуримтлагдсан үр дүн	1,169,815.4	1,422,650.1	252,834.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	738,350.2	738,350.2	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,665,174.9	1,715,625.9	265,013.8

Хүснэгтээс харахад 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна.

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 120,736.0 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 7,129.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 137,402.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 16,840.0 мянган төгрөг нийт 154,242.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 147,112.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 137,148.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 37,209.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй болон шилжиж ирсэн 214,217.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 251,620.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 7,576.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 110,561.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

- Өглөгийн талаар: Тайлант хугацаанд 12,179.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны түлш, халаалтын төлбөрийг төлөөгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Засгийн газрын хувь оролцоо: Тайлант оны үр дүн 252,834.7 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтэд гол нөлөөлөл үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,310,300.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,310,300.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 02 албан тоотой дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 65,030.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,245,270.0 мянган төгрөгөөр баталсан байгаа нь шалгагдагч байгууллагын хүргүүлсэн саналын үндэслэлийг харгалзан баталдаггүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 211,775.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн мэргэжлийн боловсролын 71801 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,336,309.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,124,533.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,335,577.4 мянган төгрөг буюу 92 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны нэмэгдэл цалин, нормативд зардал, бусад урсгал шилжүүлэг бусад зардлуудаас 120,736.1 мянган төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Сургуулийн өмнөх боловсрол-71801	1,245,270.0	1,124,533.9	120,736.1	90.3
1.1	Байр ашиглалтын үйлчилгээ-80226	2,825.3	2,771.3	54.0	98.1
1.2	Сургалт семинар-80312	2,119.1	706.4	1,412.7	33.3
1.3	Эрүүл мэндийн дэмжих-81605	2,825.3	2,267.0	558.3	80.2
1.4	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг-80101	5,520.7	5,520.7		
1.5	Дотуур байрны үйлчилгээ-81806	93,580.6	84,494.8	9,085.8	90.1
1.6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816	74,418.6	37,209.3	37,209.3	50.0
1.7	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх-81823;81827	20,763.8	6,648.1	14,115.7	32.0

1.8	Үдийн цай хөтөлбөр-80101	75,740.2	53,906.5	21,833.7	71.1
1.9	Боловсролын стандарт, сургалт-81834	799,092.7	808,872.3	9,779.0	101.2
1.10	Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835	166,701.1	120,454.9	46,246.2	72.2
1.11	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт-81844	150.6	150.6		
1.12	Сурах бичгийн түрээс-	1,532.0	1,532.0		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн хэрэгжиж буй төсөл хөтөлбөр 74,89 хувиар хэрэгжсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Я.Оюун, шинжээч Ц.Цацрал, Х.Ариунжаргал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт орлогын 3,824,912.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 38,011.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28,508.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, төвийн захирал албан томилолтоор ажилласан зардлаа авахгүй байх зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь, хугацаа хоцорсон 1 мэдээлэл байршуулж, мэдээлэлгүй 5 мэдээлэл байршуулаагүй байна.

2 Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр 59,050.8 мянган төгрөгийн мэдээлэл дутуу мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр хөрөнгийн хэмжээ 1,000.0 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 602,708.4 мянган төгрөг 601,708.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь хөрөнгө өр төлбөр болон өмчийн хувь оролцоог зөв дүнгээр тусгасан ба үнэлгээ болон хуваарилалтын залруулга, холбогдох тодруулгыг зохих ёсоор хэмжсэн тайлбарласан байх “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

4.4.2.2 Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 89,215.2 мянган төгрөгийн баримт илүү бүртгэгдсэн баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Засварын аудитаар 6 алдаа зөрчил илрүүлэн танилцуулсан боловч, алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайланд илрүүлсэн 81,363.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,407.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 1.6 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт					
Албан шаардлага	2	81,363.4	1	1,310.4	1.6
Зөвлөмж	1	1,407.5			
Нийт дүн	3	82,770.9	1	1,310.4	1.6

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулдаг эсэх, харьцуулалт сонгон шалгаруулалт хийдэг эсэх, гэрээ хэлцэл албан бичиг хэргийн стандартын хэрэгжилт үзэх, өмнөх аудитын хэрэгжилт биелэлтийг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 893.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 893.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж хүргүүллээ.

5.2 Албан шаардлага

5.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 893.8 мянган төгрөгөөр дутуу хөтөлж баримтжуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бичиг хэрэг хөтлөлтийн талаар

Илрүүлэлт:

Аудитад үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийн талаар тайлан, санхүүгийн тодруулга тайлан ирүүлээгүй байгаа нь байгаа нь албан хэрэг хөтлөлтийн стандарттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: MNS5140-2:2021 Албан хөрөнгө хөтлөлтийн стандартыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Бараа материал худалдан авах анхан шатны баримт дутуу бүртгэгдсэн.	1	893.8			1	893.8							
Үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийн талаар тайлан, санхүүгийн тодруулга тайлан ирүүлээгүй	1				1		1						
Дүн	2	893.8			1	893.8	1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
хугацаа хоцорсон 1 мэдээлэл, 5 мэдээлэл байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээллийг мэдээлээгүй	1	59,050.8			1	59,050.8		
Дүн	1	59,050.8			1	59,050.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн газрын оролцоо 601,708.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	601,708.4					1	601,708.4

Цахим баримтын бүрдэлд 89,215.2 мянган төгрөгийн баримт илүү бүртгэгдсэн	1	89,215.2			1	89,215.2		
Дүн	2	690,923.6			2	89,215.2	1	601,708.4
Нийт дүн	3	749,974.4			2	148,266.0	1	601,708.4



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 14-14510516-ТӨА-2024/

Зуунмод

1259/ТӨА-СТА-ТУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримт 89,215,200 /наян есөн сая хоёр зуун арван тайван мянга хоёр зуун/ төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Бумдарь, нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


/С.ОЮУНГЭРЭЛ/





ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 15-14510516-ТӨА-2024/

Зуунмод

259/НА-СТ-ТШБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 59,050,800 /тавин есөн сая тавин мянга найман зуун/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, хугацаа хоцорсон 1 мэдээлэл, 5 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх;

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2. Цаашид алдаа⁴, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Бумдарь, нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



⁴Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 16-14510516-ТӨА-2024/

Зуунмод

659/НА-СТА-1105

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 893,800 /найман зуун ерэн гурван мянга найман зуун/ төгрөгөөр дутуу хөтөлж бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт⁵ ирүүлэх;

⁵Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2. Цаашид алдаа⁶, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Бумдарь, нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

⁶Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

